



**НИЙСЛЭЛИЙН
АГААРЫН БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2018 оны 11 сарын 15 өдөр

Дугаар A/56

Улаанбаатар хот

┌ Ажлын хэсэг байгуулах тухай ┐

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай 3 дугаар зүйлийн 3.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг /цахим хуудас/ сайжруулах, мэдээллийг тогтмол болон тухай бүр шинэчилж байх үүрэг бүхий байнгын ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: /Захиргааны хэлтсийн дарга/

Гишүүд: /Хүний нөөц, хуулийн асуудал хариуцсан мэргэжилтэн/

/Төсөв, эдийн засгийн тооцоо, судалгаа хариуцсан мэргэжилтэн/

/Гаргалтын загварчлал хариуцсан мэргэжилтэн/

Нарийн бичгийн дарга: /Хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн/

2. Байгууллагын мэдээллийн ил тод байдлын холбогдох мэдээллүүдийг цахим хуудсанд бүрэн байршуулж үр дүнг тооцож тайлагнах, мэдээллийг тогтмол болон тухай бүр шинэчилж байхыг Ажлын хэсэгт даалгасугай.

ДАРГА *Б.Цацрал* Б.ЦАЦРАЛ

